



**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН
ХАРЬЯА ТӨВ АЙМГИЙН АУДИТЫН
ГАЗАР**

41000 Зуунмод, Төв аймаг

Утас: 70272248, Факс: 70272582, e-mail: tuv@audit.gov.mn

2016.08.26 № 1/59

танай _____ -ны № _____ -г

Аудитын гэрчилгээ

ТӨВ АЙМГИЙН ЦАГДААГИЙН ГАЗРЫН
ДАРГА А.БАТБАЯР ТАНАА

Төв аймгийн Цагдаагийн газрын төсвийн 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх дуусвар болсон, аккрузал сууриар бэлтгэгдсэн, жилийн эцсийн санхүүгийн тайланд Төрийн аудитын тухай хуулийн 15.1.1-д заасан бүрэн эрхийн дагуу Төв аймгийн аудитын газраас аудит хийв.

Төсвийн шууд захирагч нь тайлант хугацааны санхүүгийн тайланг холбогдох хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу үнэн зөв бэлтгэж, тайлагнах үүрэг, хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллага нь Төсвийн шууд захирагчийн 2015 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, санал дүгнэлт өгөх үүрэг, хариуцлага хүлээнэ.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журам нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар төсвийн шууд захирагчийн 2015 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем, гол хууль тогтоомжуудын мөрдөлтийг болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан материаллаг алдаагүй эсэхэд санал дүгнэлт өгөх хангалттай бөгөөд зохистой үндэслэлийг бүрдүүлсэн.

Зөрчилгүй санал дүгнэлт

Төв аймгийн Цагдаагийн газрын төсвийн 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан, илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Л.ЖАРГАЛСАЙХАН